

“ЭРҮҮЛ-АЮУЛГҮЙ АЖЛЫН БАЙРЫГ ЭРХЭМЛЭГЧ БАЙГУУЛЛАГА” ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Үйлдвэрлэлийн орчин, ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийг сайжруулж, ажилтныг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, бусад эрсдлээс хамгаалах, урьчилан сэргийлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагаас явуулж буй үйл ажиллагаа, санаачлагыг урамшуулан дэмжих, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд энэ журмын зорилго оршино.

Хоёр. Шалгаруулах үзүүлэлт

2.1 “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулалтанд оролцогч байгууллагыг дараах үзүүлэлтээр шалгаруулна.

2.1.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллаж, шаардагдах хөрөнгийг жил бүр төсөвтөө тусган зарцуулдаг байх;

2.1.2 Ажилтныг хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслээр хангасан байх;

2.1.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийт ажилтны сургалтыг зохион байгуулж, аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгдөг байх;

2.1.4 Түр амарч дулаацах, сэрүүцэх, хооллох ахуйн байр болон алжаал /стресс, сэтгэлийн хямрал/ тайлах, чийрэгжүүлэх, дасгал хөдөлгөөн хийх өрөө танхимаар ажилтан хангагдсан байдал;

2.1.5 Ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх болон хугацаат үзлэг, нарийн шинжилгээнд хамруулсан байдал;

2.1.6 Үйлдвэрлэлийн орчин, барилга байгууламж, машин механизм, тоног төхөөрөмжийн болон бусад шаардлага, стандартыг хангасан байдал;

2.1.7 Үйлдвэрлэлийн зохион байгуулалтын дэг, журам, аюулгүй ажиллагааны соёл, хандлага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийг бий болгосон байдал.

2.2 Дээрх үзүүлэлтүүдийг 100 онооны системээр дүгнэнэ. Дүгнэх үзүүлэлтийн нарийвчилсан шалгуурыг мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцөл хариуцсан байгууллага батална.

Гурав. Шалгаруулах ажлын зохион байгуулалт

3.1 Шалгаруулалтыг дараахь салбарын ангиллаар зохион байгуулна.

3.1.1 Уул уурхай, олборлолт

3.1.2 Барилга

3.1.3 Боловсруулах үйлдвэрлэл

3.1.4 Эрчим хүч, цахилгаан хангамж

3.1.5 Зам тээвэр

3.1.6 Бусад /боловсрол, эрүүл мэнд, худалдаа, үйлчилгээ, батлан хамгаалах, төрийн тусгай чиг үүрэг гүйцэтгэдэг салбар зэрэг/

3.2 Энэхүү журамд заасан салбарын ангилал тус бүрээр 50 хүртэл ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага болон 51-с дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага гэсэн 2 ангилал болгон шалгаруулалтанд оролцуулна.

3.3 Харъяалах аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулалтанд оролцохоор ирүүлсэн материалыг жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны дотор бүртгэн, хүлээн авна.

3.4 Аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь бүртгэн хүлээн авсан материалыг 01 дүгээр сарын 30-ны дотор дараах байгууллагад тус тус хүргүүлнэ.

а. 3.1.1-3.1.5-д хамаарах байгууллагын материалыг холбогдох яамны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороонд;

б. 3.1.6-д хамаарах байгууллагын материалыг харъяалах аймаг, дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлд.

3.5 Эхний шатны шалгаруулалт:

3.5.1 Аймаг, дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл нь энэ журмын 2.1-д заасан шалгуурыг үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулж, дүгнэсэн дүн, шалгарсан нэг байгууллагын материалыг 03 дугаар сарын 01-ний дотор мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцөл хариуцсан байгууллагад ирүүлнэ.

3.5.2 Яамны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо нь энэ журмын 2.1-д заасан шалгуурыг үндэслэн энэ журамд заасан өөрийн харъяалах салбарын ангилал тус бүрээр таван аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулж, дүгнэсэн дүн, холбогдох материалыг 03 дугаар сарын 01-ний дотор мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцөл хариуцсан байгууллагад ирүүлнэ.

3.6 Хоёр дахь шатны шалгаруулалт:

3.6.1 Мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцөл хариуцсан байгууллагын захирлын шийдвэрээр “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулах ажлын хэсгийг байгуулж ажиллуулна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн даатгал болон мэргэжлийн хяналтын байгууллага, холбогдох салбарын байгууллагын төлөөллийг оролцуулна.

3.6.2 Ажлын хэсэг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо болон зөвлөлөөс ирүүлсэн материалыг энэ журмын 2.1-д заасан шалгуурыг үндэслэн 3 дугаар сарын 25-ны дотор сонгон шалгаруулж, дүнгээ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван талт Үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлнэ.

3.6.3 Ажлын хэсгийн гишүүд онооны дарааллаар дүгнэгдсэн том болон жижиг аж ахуйн нэгж байгууллага тус бүрээс эхний 10 байранд орсон байгууллагын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцсаны үндсэн дээр эцсийн сонгон шалгаруулалтыг хийн, дүнгээ гаргана.

3.7 “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”-ын шалгаруулалттай холбоотой зардлыг дараахь арга хэмжээнд зарцуулна.

3.10.1 шагнал, урамшууллын зардал;

3.10.2 сургалт, сурталчилгааны зардал;

3.10.3 зохион байгуулалтын зардал.

Дөрөв. Материалд тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг

4.1 Шалгаруулалтад оролцох байгууллага нь дараах материалыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

4.1.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчин, ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд авсан тодорхой арга хэмжээ, хүрсэн үр дүнгийн талаарх мэдээ, баримт (фото зураг, видео бичлэг болон бусад хэлбэрээр баталгаажуулсан);

4.1.2 Энэ журмын 2.1-д заасан үзүүлэлт тус бүрээр гаргасан хэрэгжилтийн тайлан;

4.1.3 Харъяа аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэл төлсөн эсэх талаар тодорхойлолт;

4.1.4 Ажлын байрандаа эрсдлийн үнэлгээ хийсэн болон хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийлгүүлсэн дүгнэлт, үнэлгээний дагуу авсан арга хэмжээний тайлан;

4.1.5 Ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байдал, холбогдох байгууллагын тодорхойлолт;

4.1.6 Өмнөх онд үйлдвэрлэлийн осолгүй ажилласан талаарх аймаг, дүүргийн мэргэжлийн хяналтын байгууллагын тодорхойлолт.

Тав. Шагнал, урамшуулал

5.1 Энэхүү журмын дагуу “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”-аар шалгарсан аж ахуйн нэгж байгууллагад салбарын ангилал болон ажилтнуудын тооноос хамааруулан дараах өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

5.1.1 Уул уурхай, олборлолтын салбарын “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”

50 хүртэл ажилтантай-1. Өргөмжлөл. 1.5 сая төгрөг.

51-с дээш ажилтантай-1. Өргөмжлөл 2.5 сая төгрөг.

5.1.2 Барилгын салбарын “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”

50 хүртэл ажилтантай-1. Өргөмжлөл. 1.5 сая төгрөг.

51-с дээш ажилтантай-1. Өргөмжлөл 2.5 сая төгрөг.

5.1.3 Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”

50 хүртэл ажилтантай-1. Өргөмжлөл. 1.5 сая төгрөг.

51-с дээш ажилтантай-1. Өргөмжлөл 2.5 сая төгрөг.

5.1.4 Эрчим хүч, цахилгаан хангамжийн салбарын “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”

50 хүртэл ажилтантай-1. Өргөмжлөл. 1.5 сая төгрөг.

51-с дээш ажилтантай-1. Өргөмжлөл 2.5 сая төгрөг.

5.1.5 Зам тээврийн салбарын “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”

50 хүртэл ажилтантай-1. Өргөмжлөл. 1.5 сая төгрөг.

51-с дээш ажилтантай-1. Өргөмжлөл 2.5 сая төгрөг.

5.1.6 Бусад салбарын “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”

50 хүртэл ажилтантай-1. Өргөмжлөл. 1.5 сая төгрөг.

51-с дээш ажилтантай-1. Өргөмжлөл 2.5 сая төгрөг.

5.2 “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”-аар 3 дахь удаа шалгарсан бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагад өргөмжлөл, мөнгөн шагналын хамт цом гардуулна.

5.3 “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”-аар шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагуудад өргөмжлөл, мөнгөн шагналыг жил бүрийн 4 дүгээр сард гардуулна.

5.4 “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”-аар шалгарсан байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, сайн туршлагыг олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилах бусад аж ахуйн нэгж, байгууллагуудад түгээн дэлгэрүүлэх ажлыг мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцөл хариуцсан байгууллага зохион байгуулна.

5.5 Аймаг, нийслэл дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл нь энэ журмын 3.5-д заасны дагуу шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагыг сурталчилах, түгээн дэлгэрүүлэх ажлыг орон нутагтаа хариуцан зохион байгуулна.

5.6 Энэ журмын дагуу шалгарсан аж ахуйн нэгж, байгууллага нь ажлын байрны орчин нөхцлийг сайжруулж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлсэн сайн туршлагыг олон нийтэд сурталчилах үүрэг хүлээнэ.

5.7 Мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцөл хариуцсан байгууллага нь “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”-аар шалгарсан байгууллагуудын үйл ажиллагаа, сайн туршлагыг сурталчилах, түгээн дэлгэрүүлэх талаар хийсэн ажил, зохион байгуулсан арга хэмжээний талаарх тайланг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван талт Үндэсний хорооны хуралд тухайн оны хоёрдугаар улиралд багтаан танилцуулна.

--- оОо ---